



УВС АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Увс аймгийн Өмнөговь сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: УВА-2026/162/НА-СТА-ТШЗ

<p>Цахим хуудас: www.audit.mn Улаангом сум 2026 он</p>	<p>Увс аймаг дахь Төрийн аудитын газар, Дарга, тэргүүлэх аудитор: М.Батсуурь Утас: 70453317, Цахим хаяг: BatsuuriM@audit.gov.mn Аудитын менежер: М.Бат-Амгалан Утас: 70453799, Цахим хаяг: Bat-Amgalanm@audit.gov.mn Аудитор: Т.Ариунсайхан Утас: 70453799, Цахим хаяг: Ariunsaikhant@audit.gov.mn</p>
--	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	4
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ	6
2.1. Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан.....	6
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан.....	7
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	8
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан.....	10
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	11
2.6 Аудит хийсэн орон нутгийн төсвийн гүйцэтгэлийн тайлан	12
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА	13
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа	13
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин	13
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	13
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд	14
3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	14
3.5.1 Төсвийн төлөвлөлт	15
3.5.2 Төсвийн гүйцэтгэл.....	15
3.5.3 Нэмэлт төсөв.....	16
3.5.3 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн	16
3.5.4 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл.....	17
4. АУДИТЫН ТАЙЛАН	17
4.1 Ерөнхий зүйл	17
4.2 Материаллаг байдал	17
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт.....	18
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	18
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт.....	18
4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд.....	18
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	18
4.5.1 Завсрын аудитын талаар	18
4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн	18
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	19
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	19
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ	21

ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
ҮОМШӨ	Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчин



**УВС АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

213400, Увс аймаг, Улаангом сум,
Ө.Бадрахын гудамж
Утас: 70-45-33-17, Факс: (976)70-45-33-17,
E-mail: uvs@audit.gov.mn

2026.02.25 № УВА-2026/162/НА-СТА-ТШЗ
танай _____-ны № _____-т

УВС АЙМГИЙН ӨМНӨГОВЬ
СУМЫН ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН
СУРГУУЛИЙН ЗАХИРЛЫН АЛБАН
ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ
Ш.БАТЧУЛУУН ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Увс аймгийн Өмнөговь сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр Увс аймгийн Өмнөговь сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

АДБОУС 2706.7-д тодорхойлсон тодорхой бус байдал үүссэн, хэрэглэгчдэд хамааралтай санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудалгүй болно.

Аудитын гол асуудал

АДБОУС 2701.8-д тодорхойлсон тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх ажил гүйлгээ байхгүй болно.

8525050457

Бусад асуудлын хэсэг

Тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад санхүүгийн тайлангийн тодруулга толилуулгад тусгаагүй, аудитын хамрах хүрээний хязгаарлалтын улмаас аудитын хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй асуудал гараагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР


9065555 1525010041

М.БАТСУУРЬ

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1. Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>892,106,136.44</u>	<u>518,105,699.05</u>
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	590,938,603.48	188,730,218.49
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	590,938,603.48	188,730,218.49
3121	Төгрөг	590,938,603.48	188,730,218.49
31211	Төрийн сангийн харилцах	590,938,603.48	188,730,218.49
33	АВЛАГА	444,719.87	123,769.97
335	Бусад авлага	444,719.87	123,769.97
3351	Байгууллагаас авах авлага	444,719.87	123,769.97
35	БАРАА МАТЕРИАЛ	300,722,813.09	329,251,710.59
354	Хангамжийн материал	300,722,813.09	329,251,710.59
35410	Бичиг хэргийн материал	13,905,400.00	14,018,900.00
35420	Аж ахуйн материал	69,709,597.00	69,709,597.00
35440	Түлш, шатах тослох материал	2,304,000.00	00.00
35460	Хүнсний материал	9,920,280.00	27,651,500.00
35470	Бусад хангамжийн материал	204,883,536.09	217,871,713.59
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>3,379,844,265.07</u>	<u>3,305,865,415.81</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	3,379,844,265.07	3,305,865,415.81
392	Биет хөрөнгө	3,260,102,656.07	3,189,082,244.61
39201	Барилга, байгууламж, орон сууц	2,884,951,964.70	2,884,676,564.70
39202	Хуримтлагдсан элэгдэл	-257,951,613.69	-328,559,096.85
39203	Авто-тээврийн хэрэгсэл	37,000,000.00	37,000,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-9,558,333.23	-13,258,333.19
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	469,276,403.00	551,438,748.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	-124,749,582.18	-201,967,069.14
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	161,062,765.00	188,541,301.67
39208	Хуримтлагдсан элэгдэл	-67,453,364.68	-69,324,703.35
39214	Бусад үндсэн хөрөнгө	181,386,344.50	181,386,344.50
39215	Хуримтлагдсан элэгдэл	-57,620,224.46	-84,609,808.84
39217	Ном	43,758,297.11	43,758,297.11
393	Биет бус хөрөнгө	119,741,609.00	116,783,171.20
39301	Программ хангамж	17,510,564.00	17,510,564.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-2,850,955.00	-5,809,392.80
39303	Бусад биет бус хөрөнгө	105,082,000.00	105,082,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>4,271,950,401.51</u>	<u>3,823,971,114.86</u>
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	<u>32,070,000.00</u>	<u>58,074,375.02</u>
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	32,070,000.00	58,074,375.02
413	Өглөг	32,070,000.00	58,074,375.02
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	00.00	21,316.01
4136	Бусад өглөг	32,070,000.00	58,053,059.01
41361	Байгууллагад төлөх өглөг	32,070,000.00	57,768,026.01

41362	Хувь хүмүүст төлөх өглөг	00.00	285,033.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	4,239,880,401.51	3,765,896,739.84
51	Засгийн газрын хувь оролцоо	4,239,880,401.51	3,765,896,739.84
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	1,572,119,905.41	1,572,119,905.41
51101	Өмч: - төрийн	1,572,119,905.41	1,572,119,905.41
512	Хуримтлагдсан үр дүн	1,669,182,939.85	1,195,199,278.18
51210	Өмнөх үеийн үр дүн	1,669,182,939.85	1,669,182,939.85
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	-473,983,661.67
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	998,577,556.25	998,577,556.25
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	4,271,950,401.51	3,823,971,114.86

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	4,310,334,109.18	3,934,422,846.50
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	539,936,509.18	169,761,146.50
120	Нийтлэг татварын бус орлого	539,936,509.18	169,761,146.50
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	539,936,509.18	169,761,146.50
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	00.00	1,753,800.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	2,614,300.00	171,000.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	00.00	30,000,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	3,770,397,600.00	3,764,661,700.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	3,491,922,100.00	3,575,717,000.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	3,491,922,100.00	3,575,717,000.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	278,475,500.00	188,944,700.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	278,475,500.00	188,944,700.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	3,605,383,152.06	4,408,406,508.17
21	УРСГАЛ ЗАРДАЛ	3,605,383,152.06	4,408,406,508.17
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	3,499,213,919.49	4,255,218,626.20
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	2,475,358,003.99	3,039,267,596.24
210101	Үндсэн цалин	1,506,485,726.99	1,677,267,986.99
210102	Нэмэгдэл	859,100,052.00	1,174,560,758.24
210103	Унаа хоолны хөнгөлөлт	00.00	82,105,000.00
210104	Урамшуулал	109,772,225.00	105,333,851.01
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	309,518,536.16	376,039,637.66
210201	Тэтгэврийн даатгал	211,035,752.21	258,284,688.72
210202	Тэтгэмжийн даатгал	25,113,623.61	30,412,948.43
210203	ҮОМШӨ-ний даатгал	12,778,343.23	15,914,291.39
210204	Ажилгүйдлийн даатгал	12,097,952.39	14,147,337.07
210205	Эрүүл мэндийн даатгал	48,492,864.72	57,280,372.05
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	274,913,031.43	258,833,844.03
210301	Гэрэл, цахилгаан	22,723,778.56	35,052,668.03
210302	Түлш, халаалт	252,189,252.87	223,781,176.00

2104	Хангамж, бараа материалын зардал	49,191,784.00	38,415,000.00
210401	Бичиг хэрэг	4,378,500.00	1,780,550.00
210402	Тээвэр, шатахуун	9,165,600.00	16,258,250.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	35,647,684.00	20,376,200.00
2105	Нормативт зардал	130,919,880.00	200,761,280.00
210502	Хоол, хүнс	130,919,880.00	200,761,280.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	4,732,000.00	4,568,750.00
210604	Урсгал засвар	4,732,000.00	4,568,750.00
2107	Томилолт, зочны зардал	13,186,950.00	7,100,000.00
210702	Дотоод албан томилолт	13,186,950.00	7,100,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	68,716,613.12	57,053,650.01
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	37,269,908.22	4,485,200.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	31,446,704.90	52,568,450.01
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	172,677,120.79	273,178,868.26
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	10,682,850.00	37,078,744.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	21,744,580.00	21,241,950.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	140,249,690.79	214,858,174.26
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	106,169,232.57	153,187,881.97
2132	Бусад урсгал шилжүүлэг	106,112,864.00	153,185,400.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	94,318,600.00	153,185,400.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	11,794,264.00	00.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	56,368.57	2,481.97
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	56,368.57	2,481.97
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	704,950,957.12	-473,983,661.67
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	363,240,854.80	00.00
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	363,240,854.80	00.00
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	-363,240,854.80	00.00
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	341,710,102.32	-473,983,661.67

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	3,773,011,900.00	3,766,586,500.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	2,614,300.00	1,924,800.00
120	Нийтлэг татварын бус орлого	2,614,300.00	1,924,800.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	2,614,300.00	1,924,800.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	00.00	1,753,800.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	2,614,300.00	171,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	3,770,397,600.00	3,764,661,700.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	3,491,922,100.00	3,575,717,000.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	3,491,922,100.00	3,575,717,000.00

1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	278,475,500.00	188,944,700.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	278,475,500.00	188,944,700.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	<u>3,467,683,769.80</u>	<u>4,119,724,884.99</u>
21	УРСГАЛ ЗАРДАЛ	3,467,683,769.80	4,119,724,884.99
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	3,361,514,537.23	3,965,636,403.02
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	2,475,503,552.65	3,036,826,430.35
210101	Үндсэн цалин	1,506,631,275.65	1,716,987,813.14
210102	Нэмэгдэл	859,100,052.00	1,132,754,536.32
210103	Унаа хоолны хөнгөлөлт	00.00	81,837,018.89
210104	Урамшуулал	109,772,225.00	105,247,062.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	308,891,856.03	377,853,504.64
210201	Тэтгэврийн даатгал	211,480,472.08	258,738,021.31
210202	Тэтгэмжийн даатгал	25,113,623.61	30,580,767.60
210203	ҮОМШӨ-ний даатгал	12,778,343.23	14,983,024.74
210204	Ажилгүйдлийн даатгал	12,097,952.39	14,525,506.42
210205	Эрүүл мэндийн даатгал	47,421,464.72	59,026,184.57
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	275,419,131.43	184,974,468.03
210301	Гэрэл, цахилгаан	22,723,778.56	35,052,668.03
210302	Түлш, халаалт	252,695,352.87	149,921,800.00
2105	Нормативт зардал	138,042,660.00	213,522,000.00
210502	Хоол, хүнс	138,042,660.00	213,522,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	3,000,000.00	3,967,750.00
210604	Урсгал засвар	3,000,000.00	3,967,750.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	56,894,613.12	49,002,100.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	2,544,300.00	1,753,800.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	54,350,313.12	47,248,300.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	103,762,724.00	99,490,150.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	82,650,384.00	82,677,350.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	21,112,340.00	16,812,800.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	106,169,232.57	154,088,481.97
2132	Бусад урсгал шилжүүлэг	106,112,864.00	154,086,000.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	94,318,600.00	154,086,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	11,794,264.00	00.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	56,368.57	2,481.97
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	56,368.57	2,481.97
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	<u>305,328,130.20</u>	<u>-353,138,384.99</u>
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	52,055,000.00	49,070,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	52,055,000.00	49,070,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	52,055,000.00	49,070,000.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	52,055,000.00	49,070,000.00

6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	<u>-52,055,000.00</u>	<u>-49,070,000.00</u>
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	253,273,130.20	-402,208,384.99
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	337,665,473.28	590,938,603.48
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	590,938,603.48	188,730,218.49

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Бусад	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2024 оны 01-р сарын 01-нээрх үлдэгдэл	1,572,119,905.41	1,298,337,227.40	1,027,713,166.38	00.00	3,898,170,299.19
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00	00.00
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,572,119,905.41	1,298,337,227.40	1,027,713,166.38	00.00	3,898,170,299.19
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	0.00	13,932,000.00	0.00	00.00	13,932,000.00
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	00.00	00.00	00.00	00.00	00.00
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00	00.00
C07	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	476,339,667.08	00.00	476,339,667.08
C08	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,572,119,905.41	998,577,556.25	1,669,182,939.85	00.00	4,239,880,401.51
D01	2025 оны 01-р сарын 01-нээрх үлдэгдэл	1,572,119,905.41	998,577,556.25	1,669,182,939.85	00.00	4,239,880,401.51
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00	00.00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,572,119,905.41	998,577,556.25	1,669,182,939.85	00.00	4,239,880,401.51
D04	Үндсэн хөрөнгийн дахин	00.00	00.00	00.00	00.00	00.00

	үнэлгээний өсөлт, бууралт					
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00	00.00
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00	00.00
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	00.00	00.00	00.00	00.00	00.00
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	-473,983,661.67	00.00	-473,983,661.67
D09	2025 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,572,119,905.41	998,577,556.25	1,195,199,278.18	00.00	3,765,896,739.84

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	4,226,229,500.00	3,979,850,184.99
21	УРСГАЛ ЗАРДАЛ	4,226,229,500.00	3,979,850,184.99
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	4,072,085,300.00	3,825,764,184.99
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	3,239,052,700.00	3,036,826,430.35
210101	Үндсэн цалин	2,088,095,800.00	1,716,987,813.14
210102	Нэмэгдэл	1,078,187,700.00	1,132,754,536.32
210103	Унаа хоолны хөнгөлөлт	00.00	81,837,018.89
210104	Урамшуулал	72,769,200.00	105,247,062.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	404,881,500.00	377,853,504.64
210201	Тэтгэврийн даатгал	275,319,400.00	258,738,021.31
210202	Тэтгэмжийн даатгал	32,390,600.00	30,580,767.60
210203	ҮОМШӨ-ний даатгал	16,195,200.00	14,983,024.74
210204	Ажилгүйдлийн даатгал	16,195,200.00	14,525,506.42
210205	Эрүүл мэндийн даатгал	64,781,100.00	59,026,184.57
2105	Нормативт зардал	229,477,600.00	213,522,000.00
210502	Хоол, хүнс	229,477,600.00	213,522,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	48,268,800.00	49,002,100.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	00.00	1,753,800.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	48,268,800.00	47,248,300.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	150,404,700.00	148,560,150.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	134,136,200.00	131,747,350.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	16,268,500.00	16,812,800.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	154,144,200.00	154,086,000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	154,144,200.00	154,086,000.00

213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	154,144,200.00	154,086,000.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	3,671,597,700.00	3,577,641,800.00
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	3,671,597,700.00	3,575,717,000.00
131001	Улсын төсвөөс санхүүжих	3,671,597,700.00	3,575,717,000.00
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	00.00	1,924,800.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	00.00	1,753,800.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	00.00	171,000.00
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	00.00	590,938,603.48
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	00.00	188,730,218.49
62	АЖИЛЛАГСДЫН ТОО	97.00	88.00
620001	Удирдах ажилтан	1.00	1.00
620002	Гүйцэтгэх ажилтан	73.00	66.00
620003	Үйлчлэх ажилтан	23.00	21.00
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	97.00	88.00
650004	СӨБ болон бага, дунд боловсролын албан хаагч (ТҮБД)	74.00	67.00
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	23.00	21.00

2.6 Аудит хийсэн орон нутгийн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Гүйцэтгэл	Гүйцэтгэл
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	262,054,700.00	188,942,218.03
21	УРСГАЛ ЗАРДАЛ	262,054,700.00	188,942,218.03
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	262,054,700.00	188,942,218.03
2104	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	258,004,700.00	184,974,468.03
210301	Гэрэл цахилгаан	37,726,500.00	35,052,668.03
210302	Түлш, халаалт	219,921,800.00	149,921,800.00
210303	Цэвэр, бохир ус	356,400.00	0.00
2106	Эд хогшил худалдан авах	4,050,000.0	3,967,750.00
210604	Урсгал засвар	4,050,000.0	3,967,750.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	262,054,700.00	188,942,218.03
1310	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	262,054,700.00	188,942,218.03
132001	Орон нутгийн төсвөөс	262,054,700.00	188,942,218.03
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	00.00	00.00
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	00.00	00.00

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Увс аймгийн Өмнөговь сумын Ерөнхий боловсролын сургууль нь багш мэргэжлийн хөгжлийг дэмжих, хүүхэд бүрийн сурч хөгжих сургалтын таатай орчин бүрдүүлэн сургалтын чанар үр дүнд ахиц гаргах зорилго тавин ажиллаж байна.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Өмнөговь сумын Ерөнхий боловсролын сургуулийн төсвийн шууд захирагчийн хувьд дараах хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын Нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын хүрээнд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг явуулж байна. Үүнд:

- Боловсролын тухай хууль
- Төсвийн тухай хууль
- Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Шилэн дансны тухай хууль

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах нэмэлт, өөрчлөлтүүд орсон байна. Үүнд:

- Хөдөлмөр, нийгмийн түншлэлийн гурван талт үндэсний хорооны 2024 оны 10 дугаар сарын 07-ны өдрийн 3 дугаар тогтоолоор улсын хэмжээнд мөрдөх хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 2025 оны 04 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн сард 792.0 мянган төгрөгөөр шинэчлэн тогтоосон;
- Төрийн албаны тухай хуульд – 2025 оны 07 дугаар сарын 09-ний өдөр;
- Сангийн сайдын 2025 оны 01 дүгээр сарын 05-ны өдрийн А/3 дугаар тогтоолоор батлагдсан "Төсвийн байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам"
- Төсвийн тухай хуульд - 2025 оны 06 дугаар сарын 25-ны өдөр, 07 дугаар сарын 09-ний өдөр.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэхэд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна. Төсвийн ерөнхийлөн захирагчаас эрсдэлд суурилсан дотоод аудит хийгээгүй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Увс аймгийн Өмнөговь сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2025 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, санхүүгийн тайланг нягтлан бодох бүртгэлийн "Acolous" программ ашиглан бэлтгэж байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Увс аймгийн Өмнөговь сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2025 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2025 оны А/3 дугаар тушаалаар баталсан "Төсвийн байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам"-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 447,979.3 мянган төгрөгөөр буюу 10.5 хувиар буурсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	590,938.60	188,730.22	(402,208.38)
Авлага	444.72	123.77	(320.95)
Бараа материал	300,722.81	329,251.71	28,528.90
Үндсэн хөрөнгө	3,379,844.27	3,305,865.42	(73,978.85)
Нийт хөрөнгө	4,271,950.40	3,823,971.11	(447,979.29)
Өр төлбөр	32,070.00	58,074.38	26,004.38
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	4,239,880.40	3,765,896.74	(473,983.66)
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	4,271,950.40	3,823,971.11	(447,979.29)

Мөнгөн хөрөнгийн данс тайлант оны эхэнд 590,938.6 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байсан бол тайлант оны эцэст 188,730.2 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Авлага данс оны эхэнд 444.7 мянган төгрөгийн үлдэгдэлтэй, оны эцэст 123.8 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байгаа нь нийгмийн даатгалын шимтгэлийн авлага байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 329,251.7 мянган төгрөг болж, өмнөх оноос 28,528.9 мянган төгрөгөөр өссөн байна.

Үндсэн хөрөнгийн дансны үлдэгдэл 3,305,865.4 мянган төгрөг болж, өмнөх оноос 73,978.8 мянган төгрөгөөр буурсан байна.

Тайлант онд 58,074.4 мянган төгрөгийн өр төлбөрийн үлдэгдэлтэй байгаа нь төсөвт тусгагдсан санхүүжилт олгоогүй нь улмаас үүссэн дулаан, бензин, сургуулийн хүүхдийн үдийн хоол гэх мэт өглөгүүд байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 3,765,896.7 мянган төгрөг болж, 473,983.7 мянган төгрөгөөр буурсан нь тайлант үеийн үр дүнгээс шалтгаалжээ.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2025 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 3,805,183.8 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчид хүргүүлсэн төсвийн төслөөс улсын төсвийн санхүүжилтийг 139,563.3 мянган төгрөгөөр бууруулж, 3,665,620.5 мянган төгрөгөөр баталсан байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 14 арга хэмжээг санхүүжүүлэх 4,238,783.2 мянган төгрөгийг улсын төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 3,575,717.0 мянган төгрөг, орон нутгийн санхүүжилтээр 188,944.7 мянган төгрөг, төсөвт байгууллагын өөрийн орлогоос 1,924.8 мянган төгрөг, өмнөх оны санхүүжилт 590,938.6 мянган төгрөг, нийт 4,357,525.1 мянган төгрөгийн санхүүжилт бүрдүүлж, урсгал үйл ажиллагааны зардалд 4,168,792.4 мянган төгрөгийг зарцуулснаас орон нутгийн төсөвт 2.4 мянган төгрөг төвлөрүүлж, 188,730.2 мянган төгрөгийн харилцахын үлдэгдэлтэй байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөгөөр/

Д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
1	Байр ашиглалтын үйлчилгээ /80226/	4,583.80	4,582.50	1.30	99.97%
2	Хүүхэд хамгаалал /80233/	4,715.00	4,489.00	226.00	95.21%
3	Сургалт семинар /80312/	2,691.90	2,691.90	-	100.00%
4	Эрүүл мэндийг дэмжих/81605/	5,018.60	5,018.00	0.60	99.99%
5	Үдийн цай /81801/	154,144.20	154,086.00	58.20	99.96%
6	Дотуур байрны үйлчилгээ /81806/	637,602.90	629,464.88	8,138.02	98.72%
7	Хүүхдэд ээлтэй сургалтын орчин /81816/	78,020.90	78,020.00	0.90	100.00%
8	Боловсролын байгууллагын багш ажилтны мэргэжил дээшлүүлэх /81823/	9,055.50	9,158.80	(103.30)	101.14%
9	Бичиг үсгийн боловсролын хөтөлбөр /81827/	33,537.50	31,615.14	1,922.36	94.27%
10	Боловсролын стандарт сургалт /81834/	2,657,561.70	2,984,167.01	(326,605.31)	112.29%
11	Сургалтын хэвийн үйл ажиллагаа /81835/	67,113.90	58,271.85	8,842.05	86.83%
12	Сургуулийн нэмэлт хөтөлбөр хэрэгжүүлэх /81875/	17,551.80	16,531.30	1,020.50	94.19%
13	Сурах бичгийн түрээс /81848/	1,753.80	1,753.80	-	100.00%
14	Нэмэлт-Дээд шатны төсвөөс хуваарилсан /83603/	1,710.00	0.00	1,710.00	0.00%

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

Аудитын ерөнхий чиглэлийн судалгааны дүн

/мянган төгрөг/

Д/д	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Тайлбар
1	Программ хангамжийн бүртгэл	-	-	Нягтлан бодох бүртгэлийн "Acolous" программыг ашиглаж байна.
2	Унаа, хоолны зарцуулалт	-	81,837.0	Монгол Улсын Боловсролын сайдын 2025 оны 02 дугаар сарын 11-ний өдрийн 1/554 тушаалыг үндэслэн Өмнөговь сумын Ерөнхий боловсролын сургуулийн захирлын 2025 оны 02 дугаар сарын 17-ний өдрийн Б/12 дугаар тушаалаар багш, ажилтанд хоолны зардлыг өдрийн 5,000.0 төгрөгөөр тооцон олгох шийдвэр гарсан байна. Тайлант онд 81,837.0 мянган төгрөгийн хоолны зардал олгосон байна.
3	Сургалт, семинар, хурал зөвлөгөөний зардал	-	4,950.5	Өмнөговь сумын ЕБС нь ЕБС-ийн оновчтой менежмент, удирдлагын багийн нэгдмэл ойлголт, хамтын ажиллагааг сайжруулах, багшийг ажлын байранд нь хөгжүүлэхэд чиглэсэн онол, практик хосолсон сургалт, төрөлжсөн цахим сургалт, сургалтын менежерүүдийн мэргэжлийн хөгжлийг дэмжих, чадавхжуулах сургалтуудыг тус тус зохион байгуулсан байна.
4	Гадаад томилолт, арга хэмжээ	-	-	Зардал гараагүй.
5	Төрд учирсан хохирлыг барагдуулахтай холбоотой зардал	-	-	Зардал гараагүй.
6	Орон тоо	3,239,052.7	3,036,826.4	Сумын Ерөнхий боловсролын сургуулийн захирлын 2025 оны 01 дүгээр сарын 06-ны өдрийн "Бүтэц орон тоог шинэчлэн батлах тухай" А/01 тушаалаар 97 орон тоо баталснаас тайлант онд 88 албан хаагчтайгаар үйл ажиллагаагаа явуулсан байна.
7	Хэвлэл мэдээлэл	-	-	Зардал гараагүй.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т "нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна" гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй. Өмнөговь сумын Ерөнхий боловсролын сургуулийн нэмэлт санхүүжилтийн дансаар орлого, зарлага гараагүй байна.

3.5.3 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Өмнөговь сумын Ерөнхий боловсролын сургуульд тайлант онд хэрэгжүүлсэн төсөл, хөтөлбөр байхгүй байна.

3.5.4 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Өмнөговь сумын Ерөнхий боловсролын сургууль нь тайлант онд 173,470.3 мянган төгрөгийн төсөвт өртөгтэй сургуулийн хүүхдийн хоолны материал /багц 1:мах, багц 2: сүү, сүүн бүтээгдэхүүн, багц 3: хүнсний бусад/, 310,951.6 мянган төгрөгийн төсөвт өртөгтэй дотуур байрны хоолны материал /багц 1: мах, багц 2: сүү, сүүн бүтээгдэхүүн, багц 3: хүнсний бусад/ гэсэн 2 нээлттэй худалдан авах ажиллагааг зохион байгуулсан байна. Мэргэшсэн ажилтнаас бүрдсэн үнэлгээний хороо 2025 оны 02 дугаар сараас эхлэн худалдан авах ажиллагааг хуульд журамд нийцүүлэн зарласан бөгөөд мах, хүнсний бусад багцад хамгийн сайн үнэлэгдсэн оролцогчтой гэрээ байгуулсан байна. Харин сүү, сүүн бүтээгдэхүүн нийлүүлэх багцад оролцогч ороогүй нь улмаас түр гэрээ байгуулан шууд худалдан авалт хийж байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Увс аймгийн Өмнөговь сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторовын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Увс аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Т.Ариунсайхан гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер М.Бат-Амгалан, дарга, тэргүүлэх аудитор М.Батсуурь нар тус тус хэрэгжүүлсэн.

Увс аймгийн Өмнөговь сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлгэх хүсэлтийг Увс аймаг дахь Төрийн аудитын газарт Увс аймгийн Өмнөговь сумын Ерөнхий боловсролын сургуулийн захирлын албан үүргийг түр орлон гүйцэтгэгчийн 2026 оны 01 дүгээр сарын 13-ны өдрийн 02 дугаар албан бичгээр ирүүлсэн.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “Дунд” гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2024 оны Санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 3,605,383.2 мянган төгрөгийн 1 хувиар буюу 36,053.8 мянган төгрөгөөс 80 хувиар тооцож 28,843.1 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагатай гэж үзсэн.

Гүйцэтгэлийн шатанд материаллаг байдлыг 2025 оны Санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 4,408,406.5 мянган төгрөгийн 1 хувиар буюу 44,084.1 мянган төгрөгөөс 80 хувиар тооцож 35,267.3 мянган төгрөгөөр тогтоосон.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор Өмнөговь сумын Ерөнхий боловсролын сургуулийн тухайн хуульд хамаарах зүйл заалтын хүрээнд горим сорил хэрэгжүүлсэн. Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил гараагүй болно.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Увс аймгийн Өмнөговь сумын Ерөнхий боловсролын сургууль нь тайлант хугацаанд www.shilendans.gov.mn цахим хуудсанд оруулбал зохих 171 мэдээллээс хугацаандаа оруулсан 164, хугацаа хоцроосон 5, хугацаа болоогүй хүлээгдэж байгаа 2 мэдээлэл байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Төрийн аудитын байгууллагаас 2025-2026 онд гүйцэтгэх санхүүгийн тайлангийн аудитаар баримтлах ерөнхий чиглэлд тусгагдсан болон бусад хууль тогтоомжтой холбоотой хэрэгжүүлсэн горим сорилын хүрээнд зөрчил илрээгүй болно.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Увс аймгийн Өмнөговь сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2025 оны санхүүгийн тайлангийн завсрын аудитаар төрийн үйлчилгээний албан хаагч болох жолооч, сантехникчид илүү цагаар ажилласны нэмэгдэл хөлс олгохдоо Засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтаар баталсан Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчид нэмэгдэл хөлс олгох журамд заасан хувь хэмжээг хэтрүүлэн олгосон зөрчил илэрсэнд зөвлөмж өгсөн.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 1,256.5 мянган төгрөгийн зөрчилд зөвлөмж өгчээ. Аудитаар өгсөн зөвлөмж бүрэн хэрэгжсэн бөгөөд Өмнөговь сумын Ерөнхий боловсролын сургуулийн захирлын үүргийг түр орлон гүйцэтгэгчийн 70 дугаар албан бичгээр зөвлөмжийн биелэлтийг ирүүлсэн.

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Зөвлөмж	1	1,256.5	1	1,256.5	100.0%
Нийт дүн	1	1,256.5	1	1,256.5	100.0%

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 дүгээр хэсэгт “Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно”, 13.4 дүгээр хэсэгт “Аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, нягтлан бодогч нь үйлдвэрлэл, үйлчилгээний шат дамжлага, аж ахуйн үйл ажиллагааны хүрээнд гарсан хөрөнгө, эх үүсвэрийн хөдлөл, өөрчлөлт бүрийг анхан шатны баримтад бичгээр болон цахимаар бичилт хийж баталгаажуулна”, 20.1 дүгээр хэсэгт “Аж ахуйн нэгж, байгууллагын ерөнхий нягтлан бодогч мэргэжлийн ур чадвар, ёс зүйтэй байх бөгөөд дараах бүрэн эрхтэй байна”, 20.1.4 дэх заалтад “хүчин төгөлдөр бус анхан шатны баримтаар, эсхүл анхан шатны баримтаар баталгаажуулаагүй ажил, гүйлгээг бүртгэхгүй байх” гэж заасны дагуу хөрөнгө зарлага болгох болон орлогод авахдаа тушаал шийдвэрээр баталгаажуулж байхыг дараагийн аудитаар анхаарах нь зүйтэй гэж үзлээ.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 48,564.8 мянган төгрөгийн 2 алдаа илэрснийг залрууллаа.

5.1 Залруулсан алдаа:

1. Өмнөговь сумын Ерөнхий боловсролын сургууль нь нэг албан хаагчийн хөдөлмөрийн чадвар түр алдсаны 285.0 мянган төгрөгийн олгогдоогүй тэтгэмжийг өглөгөөр тусгаагүй орхигдуулсан нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсэгт “Аж ахуйн нэгж, байгууллага нягтлан бодох бүртгэлийн дараах зарчмыг баримтална”, 5.1.4 дэх заалтад “үнэн зөв байх”, 14 дүгээр зүйлийн 14.4 дэх хэсэгт “Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ”, 14.4.3 дахь заалтад “бүх өр төлбөр”, 20 дугаар зүйлийн 20.2 дахь хэсэгт “Ерөнхий нягтлан бодогч дараах үүрэг хүлээнэ”, 20.2.5 дахь заалтад “дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах” гэж заасантай нийцэхгүй, Иж бүрэн байх батламж мэдэгдлийг хангахгүй байсан тул залруулга хийлгэлээ.

2. Өмнөговь сумын Ерөнхий боловсролын сургууль нь үр дүнгийн тайланд тээвэр шатахууны зардлыг 6,634.1 мянган төгрөг, бараа үйлчилгээний зардлыг 15,163.6 мянган төгрөг, хичээл сургалт, үйлдвэрлэлийн дадлагын зардлыг 76.0 мянган төгрөгөөр дутуу, бага үнэтэй түргэн элэгдэх зүйлсийн зардлыг 26,406.1 мянган төгрөгөөр илүү илэрхийлсэн нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4 дэх заалтад “үнэн зөв байх” 14 дүгээр зүйлийн 14.4 дэх хэсэгт “Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ”, 14.4.6 дахь заалтад “Бүх зардал” гэж заасантай нийцэхгүй, Төлилуулга батламж мэдэгдлийг хангахгүй байсан тул залруулга хийлгэлээ.

5.2 Зөвлөмж

1. Хууль тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой

1.1. Илрүүлэлт:

Төрийн үйлчилгээний албан хаагч болох жолооч, сантехникчид илүү цагаар ажилласны нэмэгдэл хөлс 6,846.6 мянган төгрөгийг илүү тооцож олгосон нь Засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтаар баталсан Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчид нэмэгдэл хөлс олгох журмын нийтлэг үндэслэлийн 3-д “Хөдөлмөрийн тухай хуульд заасны дагуу төрийн байгууллагын дотоод журмаар тогтоосон өдрийн ажлын цагийг ажил олгогчийн санаачилгаар хэтрүүлэн ажиллуулахыг илүү цагаар ажиллуулсанд, орон нутгийн цагаар 22 цагаас 06 цаг хүртэлх хугацаанд ажиллуулахыг шөнийн цагаар ажиллуулсанд, нийтээр амрах баярын өдрүүдэд ажиллуулахыг нийтээр амрах баярын өдөр ажиллуулсанд, Бямба, Ням гарагт ажиллуулахыг долоо хоног бүрийн амралтын өдөр ажиллуулсанд тус тус тооцож, нөхөн амруулаагүй тохиолдолд нэмэгдэл хөлс олгоно”, 3-т “Нэмэгдэл хөлс олгох”, 3.3-д “Илүү цагаар, долоо хоногийн амралтын өдрөөр, нийтээр амрах баяр ёслолын өдрөөр, шөнийн цагаар ажилласны нэмэгдэл хөлс тооцох цаг нь 4.1-т зааснаас бусад тохиолдолд тухайн сарын ажлын цагийн 10 хувиас хэтрэхгүй байна. Тухайлбал, 8 дугаар сарын ажлын цаг 160 гэж үзвэл тухайн сард нэмэгдэл хөлс тооцогдох цаг нь 16-аас илүүгүй байна” гэж заасантай нийцэхгүй байна.

1.2. Өгсөн зөвлөмж:

- 1.1. Цаашид илүү цагаар ажилласны нэмэгдэл хөлс тооцож олгохдоо журамд заасан хувь хэмжээг мөрдөж ажиллах.

Дээрх зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор, биелэлтийг 2026 оны 05 дугаар сарын 25-ны өдрийн дотор Увс аймаг дахь Төрийн аудитын газарт тус тус ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1 албан хаагчийн хөдөлмөрийн чадвар түр алдсаны 285.0 мянган төгрөгийн олгогдоогүй тэтгэмжийг өглөгөөр тусгаагүй.	1	285.0	1	285.0			1	285.0				
Өмнөговь сумын Ерөнхий боловсролын сургууль нь үр дүнгийн тайланд нийт 21,873.7 мянган төгрөгийг дутуу, 26,406.1 мянган төгрөгийг илүү илэрхийлсэн	1	48,279.8			1	48,279.8	1	48,279.8				
Дүн	2	48,564.8	1	285.0	1	48,279.8	2	48,564.8				

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
									Тоо	Дүн	Тоо	Дүн
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Төрийн үйлчилгээний албан хаагч	1	6,846.6					1	6,846.6				

Болох жолооч, сантехникчид илүү цагаар ажилласны нэмэгдэл хөлс 6,846.6 мянган төгрөгийг илүү тооцож олгосон											
Дүн	1	6,846.6					1	6,846.6			

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Байхгүй								
Дүн								
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
Байхгүй								
Дүн								
Нийт дүн								

АУДИТЫН ТАЙЛАН

ХЯНАСАН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

АУДИТЫН МЕНЕЖЕР

БЭЛТГЭСЭН:

АУДИТОР



/М.БАТСУУРЫ/

/М.БАТ-АМГАЛАН/

/Т.АРИУНСАЙХАН/

2026.02.24